

**ЦАХИЛГААН ШУГАМ СҮЛЖЭЭНД ХОЛБОХ  
ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ №3/2019**

2019 оны 1 дүгээр сар 11-ны өдөр

1. Хэрэглэгчийн нэг, хаяг: Даланзадгад сумын ЗДТГазар.
2. Техникийн нөхцөл авах объектийн нэр, байршил: Гэр хорооллын гудамжны гэрэлтүүлэг, Даланзадгад сум
3. Хэрэгцээт хүчин чадал: (урьдчилсан тооцоогоор) **12,5 кВт**
4. Хэрэглэгчийн ажлын горим: 24 цаг
5. Хэрэглэгчийн зэрэг: Гурав
6. Холбогдох цэг: 10 кВ-ын ЦДАШ ТП-203, 115, 22 дэд станц
7. Ерөнхий шаардлага:

7.1 Хэрэглэгч нь мэргэжлийн эрх бүхий байгууллага, хуулийн этгээдээр зураг төслийг хийлгэнэ. Зураг төсөл зохиогч нь техникийн нөхцлийн дагуу зураг төслийг боловсруулж, “ӨБЦТС” ТӨХК-иар хянуулан зөвшилцөл хийж, зургийн 1 хувийг техникийн нөхцөл олгогчид өгнө.

7.2 Зураг төсөлгүй буюу зөвшилцөл хийгээгүй зураг төслөөр барилга угсралтын ажил гүйцэтгэхийг зөвшөөрөхгүй.

7.3 Хэрэглэгчийн цахилгааны шугам сүлжээг барихад газар доорхи инженерийн сүлжээг дайрч гарах зам талбай, мод бут сөөг эвдэх, тайрах тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг зураг төсөвт тусган хэрэгжүүлнэ. Хэрэглэгч нь шугам сүлжээг угсрах явцад бусад инженерийн сүлжээтэй тааралдаж байгаа бол түүнийг хамгаалах, бүрэн бүтэн байдлыг нь хариуцах үүрэгтэй

7.4 Хэрэглэгч нь цахилгааны шугам сүлжээний угсралтын ажлыг батлагдсан зураг төслийн дагуу “ӨБЦТС” ТӨХК-ийн техникийн ажилтны хяналт, зөвлөмжийн дор гүйцэтгэнэ.

7.5 Хэрэглэгч нь цахилгааны шугам сүлжээний угсралтын ажлыг хийж дууссаны дараа техникийн нөхцөл олгогчийн төлөөлөгчийг байлцуулан туршилт тохируулгын ажлыг хийж холбогдох акт баримтыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Гүйцэтгэлийн зураг
- Ажлын зураг, түүнд зураг төслийн байгууллагатай зөвшөөрөлцөж оруулсан өөрчлөлтүүд.
- Суурилагдсан тооцооны болон хяналтын хэмжүүрүүдийн паспорт, улсын баталгаажуулалтын гэрчилгээ.
- Туршилт тохируулгын баталгаажсан лабораторын акт бичиг баримт, ашиглалтын заавар.
- Кабелийн трассын координатын байршил, трассын зураг.

8. Зураг төсөл зохиох, угсралтын ажил гүйцэтгэхэд биелүүлэх шаардлага

- 10 кВ-ын Нисэх фидерийн ТП-203 дэд станцын 0.4 кВ-ын шитэнд нэмэлт гаргалгааны автомат тоноглож кабель шугамаар гаргалгаа гарган сувагжилт хийж гэрэлтүүлэгийн шит хайрцагт тэжээл татах. Уг гэрэлтүүлэгийг шитээс кабель шугамаар гаргалгаа гарган СИП кабель дамжуулагчтай агаарын шугам татаж Хан-уул, Их уул гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийг тэжээх.
- АТП-22 дэд станцын урд, хойд гаргалгааны 0.4 кВ-ын ЦДАШ-аас буулт хийж иж бүрэн 0.4 кВ-ын шит хайрцаг монтажлах. Уг гэрэлтүүлэгийг шитээс кабель шугамаар гаргалгаа гарган СИП кабель дамжуулагчтай агаарын шугам татаж Дунд сайхан гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийг тэжээх.
- ТП-115 дэд станцын хойд гаргалгааны дундын тулгуураас кабель шугамаар сувагжилт гэрэлтүүлэгийн шит хайрцагт тэжээл татах. Тус гэрэлтүүлэгийг шитээс кабель шугамаар гаргалгаа гарган СИП кабель дамжуулагчтай агаарын шугам татаж Ёл гэр хорооллын гудамжны гэрэлтүүлгийг тэжээх.
- Гэрэлтүүлэгийн бүх шит хайрцагт 100А 3н фазын тоолуур, удирдлагын фото элемент, гаргалгааны дифференциал автомат, газардуулах байгууламж, цоож, анхааруулах плакаттай байх.
- Кабель шугамын хөндлөн огтлолыг ачааллаас хамааруулж сонгож тооцох.
- Гэрэлтүүлэгийн 0.4 кВ-ын агаарын шугамын трассыг аймаг, сумын ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулж зөвшөөрөл авч хангагч байгууллагатай зөвшилцсөн байх.
- Угсралтын ажлыг эхлэхэд, үе шат бүрт хангагч байгууллагатай зөвшилцөж байх.
- Шугам, дэд станц барих угсралтын ажлыг мэргэжлийн байгууллагаар Аюулгүй ажиллагааны дүрэм болон Техник ашиглалтын дүрмийн дагуу гүйцэтгүүлэх.
- Хэрэглэгчийн цахилгааны шугам сүлжээг барихад зам талбай, мод бут сөөг эвдэх, тайрах тэдгээрийг нөхөн сэргээхэд гарах зардлыг зураг төсөөт тусган хэрэгжүүлэх.

Гүйцэтгэлийн кадастрын зураг хийж хангагч байгууллагад хүлээлгэн өгөх.  
9. Техникийн нөхцөл нь олгосон өдрөөс хойш 1 жилийн хугацаанд хүчинтэй.

10. Техникийн нөхцлийг явуулсан газрууд:

Даланзадгад сумын ЗДТГазарын дарга Ж.Даваахүү Утас:70537710

11. Техникийн нөхцлийн шаардлагуудыг хэрэглэгч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч байгууллагууд заавал биелүүлэх үүрэгтэй.

ТЕХНИКИЙН НӨХЦЛИЙГ ОЛГОСОН:

Ерөнхий инженер

ЦШС-ний албаны дарга

Хэрэглэгчдэд үйлчлэх төвийн дарга

РХТ-н инженер

Т.Гантөмөр

Б.Чинбат

Ц.Нарантуяа

С.Чулуунбаатар